



Үндэсний виз мэдүүлэх заавар

Эхнэр, нөхөр / хамтран амьдрагч руугаа нүүж очих виз

Үндсэн заавар

- Гэрлэлтийн баталгаа, төрсний гэрчилгээ болон бусад баримт бичгийн эх хувийг өгнө. Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа эх хувийг буцаан олгоно.
- Визийн мэдүүлгэд нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх явцад ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг удаашруулах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацаа дуусаагүй байхад лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх тул хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн туслалцаа, үйлчилгээг авах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.

Ерөнхий мэдээлэл

Гэр бүл рүүгээ нүүж очих визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд Германы Оршин суух тухай хуулийн 27-р зүйлийг (§§27 ff. AufenthG) баримтална.

Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө. 18 нас хүрээгүй виз мэдүүлэгч асран хамгаалах эрх бүхий хүмүүсийн хамт ирнэ. Эцэг эхийн аль нэг нь Германд амьдардаг бол нотариатаар баталгаажуулсан зөвшөөрлийг хавсаргана.

Герман дахь Гадаадын харьяат иргэдийн газар зөвшөөрлөө өгөх ёстой учраас бүрэн гүйцэд визийн мэдүүлгийг эцэслэн шийдвэрлэхэд багадаа 2 сарын хугацаа шаардлагатай. Ийм төрлийн визийн мэдүүлгийг шийдвэрлэх явцад Монголын иргэний бүртгэл мэдээлэл болон бусад холбогдох байгууллагаас олгосон гэрчилгээ, лавлагаа, шүүхийн шийдвэр, тодорхойлолт гэх мэтийн бичиг баримтын үнэн зөвийг шалгах шаардлага (Urkundenüberprüfung) олонтаа тохиолддог. Энэ нь визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацааг уртасгаж болох бөгөөд нэмэлт төлбөртэй байна. Бичиг баримт хянан шалгах тухай мэдээллийг доорх холбоосоос авна уу:

<https://ulan-bator.diplo.de/mn-de/service/-/2180306>.



Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтын жагсаалт		
<p>Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтуудыг эх хувиас гадна 2 хувь хуулбарын хамт өгнө. Визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа бичиг баримтын эх хувийг буцаан олгоно. Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө.</p> <p>Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.</p>		
1	Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт 2 хувь ("VIDEX" маягт)	<input type="checkbox"/>
2	Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ.	
3	Хүчинтэй гадаад паспорт	
4	Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрний хуулбар	
5	Гэрлэлтийн баталгаа эсвэл хамтран амьдрагчийн гэрчилгээ (Eintragung der Lebenspartnerschaft)	
6	Өмнө нь гэр бүлийн бүртгэлтэй байсан бол: гэрлэлтээ цуцлуулсан шүүхийн шийдвэр	
7	Германд байгаа гэр бүлийн хүн / хамтран амьдрагчийн оршин суугаа хаягийн бүртгэл	
8	Германд амьдарч буй эхнэр / нөхрийн гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэхний хуулбар	
9	Германы болон Европын Холбооны бус иргэдийн хувьд оршин суух зөвшөөрлийн хуулбар	
10	<p>Герман хэлний мэдлэгийн (A1 түвшин) сертификат. ALTE стандартын дагуу хэлний мэдлэгийг шалгах эрх бүхий байгууллагаас сүүлийн нэг жилийн дотор олгосон сертификат байх ёстой. Das Deutsche Sprachdiplom (DSD) – Герман хэлний дипломыг мөн хүлээн зөвшөөрнө.</p> <p><i>Герман хэлний мэдлэгийн түвшин A1 ба түүнээс дээш гэдгийг виз мэдүүлэхдээ ярилцлага хийж баталж чадвал герман хэлний сертификат өгөх журмаас чөлөөлж болно. Визийн мэдүүлгээ өгсөнөөс хойш герман хэлний сертификатыг тодорхой хугацаанд нөхөн өгч болдог бөгөөд ЭСЯ-наас энэхүү хугацааг тодорхой зааж өгнө.</i></p>	
11	Визийн хугацааг хамрах эрүүл мэндийн даатгал. Виз олгох боломжтой болсны дараа өгөх ба энэ талаар Элчин сайдын яамнаас утсаар мэдэгдэх болно	
Монголоос өөр орны иргэншилтэй виз мэдүүлэгч		
12	Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл	
Хураамж		
13	Визийн хураамж 75 еврог монгол төгрөгөөр	
Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал		

Энэхүү жагсаалтыг ЭСЯ тухайн цаг үеийн мэдлэг, дүгнэлт дээр үндэслэн гаргасан болно. Жагсаалтын бүрэн гүйцэд, үнэн зөв байдал ялангуяа цаг хугацааны хувьд гарч болох өөрчлөлтүүдийн өмнөөс ЭСЯ хариуцлага хүлээхгүй.



Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх:

Гийм

Гүгй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу

Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл

Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт дутуу байх нь визийг татгалзах эрсдэлтэй гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно.

_____ газар, огноо, гарын үсэг